



**СОНГОЛОН ХАЙРХАН ХХК-ИЙН
БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
(Дархан-Уул аймаг, Дархан сум)



Улаанбаатар хот
2026 он



АГУУЛГА

ОРШИЛ III

БҮЛЭГ 1. ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА..... 1-1

1.1	КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2	ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	1-1
1.2.1	Үйлдвэрийн байршил, орчны тойм зураг	1-1
1.2.2	Үйлдвэрийн байгууламж	1-1
1.2.3	Үйлдвэрийн хүчин чадал	1-2
1.2.4	Бүтээгдэхүүний найрлага, орцын мэдээлэл	1-2
1.2.5	Үйлдвэрийн үндсэн түүхий эд	1-3
1.2.6	Бетон зуурмагийн нэмэлт бодисын шинж чанар, хор аюул	1-3
1.2.7	Бетон зуурмагт нэмэлт бодис хийхийн давуу тал	1-4
1.2.8	Үйлдвэрийн тоног төхөөрөмж.....	1-5

1.3	ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮТЭЦ	1-5
-----	----------------------------	-----

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... 2-1

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТЗ-1

3.1	АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-1
3.2	ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-1
3.3	УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-1
3.4	ХОГ ХАЯГДЛЫН УЛМААС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-1

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 4-1

4.1	ГОЛ ЗОРИЛТ	4-1
4.2	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	4-1
4.3	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-1
4.4	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-6
4.5	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-6
4.6	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-6
4.7	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-7
4.8	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	4-10
4.9	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-12
4.10	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-12

ДҮГНЭЛТ А

ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ В

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1.	Бетон зуурмагт хэрэглэгдэх материалууд	1-3
Хүснэгт 1-2.	Бүтээгдэхүүний онцлог	1-3
Хүснэгт 1-3.	Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт	1-5
Хүснэгт 4-1:	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	4-1
Хүснэгт 4-2.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4-3
Хүснэгт 4-3.	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	4-6
Хүснэгт 4-4.	Төслөөс тэрбум мод үндэсний хөдөлгөөнд таригдах мод	Error! Bookmark not defined.
Хүснэгт 4-5.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4-7
Хүснэгт 4-6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	4-9
Хүснэгт 4-7.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	4-11
Хүснэгт 4-8.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	4-12
Хүснэгт 4-9.	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь.....	4-12

Зургийн жагсаалт

Зураг 1-1.	Бетон зуурмагийн үйлдвэрийн байршил.....	1-1
Зураг 1-2.	Ажилчдын байр.....	1-2
Зураг 1-3.	Химийн бодисын агуулах.....	1-2



ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Сонголон Хайрхан ХХК-ийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны 2022.01.12-ны өдрийн 13/207 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2022 онд Баялаг Эко ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав. Энэхүү төлөвлөгөөгөөр Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд 2026 оны БОМТ нь 2022 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн тав дах жилийн БОМТ юм.



БҮЛЭГ 1. ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА


1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	<ul style="list-style-type: none"> • Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Сонголон Хайрхан ХХК • Улсын бүртгэлийн дугаар: 9011179051 • Регистрийн дугаар: 5276764 • Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг • Утас: +976 98009669 +976 99220394 • Цахим шуудан: songolon_h@yahoo.com

1.2 ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.2.1 Үйлдвэрийн байршил, орчны тойм зураг

Сонголон Хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлана. Төслийн талбайн хэмжээ 0.8664 га бөгөөд байршлыг Зураг 1-1-т тусгав.



Зураг 1-1. Бетон зуурмагийн үйлдвэрийн байршил

Сонголон Хайрхан ХХК нь Талын торгон зам ХХК-иас нэмэлт бодис хадгалах агуулахыг түрээслэн ажилладаг.

1.2.2 Үйлдвэрийн байгууламж

Тус үйлдвэр нь оффисын зориулалттай контор, 369 м² байр, үйлдвэрлэлийг шууд удирдан хянах 16 м² байр зэргээс бүрдэнэ.



Зураг 1-2. Ажилчдын байр



Зураг 1-3. Химийн бодисын агуулах

1.2.3 Үйлдвэрийн хүчин чадал

Сонголон Хайрхан ХХК нь чанарын шаардлага хангасан бетон зуурмагийн өвөл зуны нэмэлт бодисыг Талын торгон зам ХХК-тай гэрээ байгуулан худалдан авч, үйл ажиллагаандаа ашигладаг. Бетон зуурмагийн үйлдвэр нь жилд дунджаар 45 тн химийн нэмэлт бодис хэрэглэдэг. Бетон зуурмагийн үзель нь цагт 60 м³ бетон зуурмаг зуурах хүчин чадалтай бөгөөд уг үйлдвэрт 4 хүн ажилладаг.

1.2.4 Бүтээгдэхүүний найрлага, орцын мэдээлэл

Бетон зуурмагийн зохистой найрлагыг цементийн анги, дүүргэгчийн шинж чанар, нэмэлтийн төрлөөс хамааруулан тухай бүр зохицуулан сонгодог бөгөөд C7.5-C40 ангийн M100-M500 маркийн хооронд бетон зуурмаг үйлдвэрлэдэг. Үүнд бетон зуурмагийн анги, маркаас хамаарч 1 м³ бетон зуурмагт ус цементийн харьцаа 0.35-0.53 байх ба 980-1100 кг элс, 740-840 кг дайрга, 160-195 л ус, 260-550 кг цемент, 2.6-5.5 гр нэмэлт бодис тус тус хэрэглэдэг.



1.2.5 Үйлдвэрийн үндсэн түүхий эд

Түүхий эд материал цементийг цементвозоор тээвэрлэн зуурмагийн үзелийн цементийн силосонд шахна. 7 хоногийн нөөцтэйгөөр үйл ажиллагаагаа явуулна. Элсийг тусгайлан зассан бетондсон талбайд буулгаж хадгална. Хайрга дайргыг тусгайлан зассан зориулалт бүхий бетондсон талбайд фракц фракцаар нь ангилан буулгаж хадгална. Ойролцоогоор 10,000 м³-ийн нөөцтэйгөөр үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зохицуулалт хийдэг байна.

Үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох цементийг Хөтлийн “Цемент-Шохой” ТӨХК-иес тусгай зориулалтын цементвозоор тээвэрлэж авдаг. Цемент хадгалах 150 тонны багтаамжтай 2 ш, 120 тонны багтаамжтай 1ш силостой мөн 3000-4500 м³ элс болон дайрга агуулах талбайтай. Дүүргэгч материал болох 0-5 мм элс, 10-20 мм дайргыг өөрийн компанийн элсэн карьер болгон бутлан ангилж боловсруулах үйлдвэрээс авдаг.

Хүснэгт 1-1. Бетон зуурмагт хэрэглэгдэх материалууд

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Нийлүүлэгч	Сарын хэрэгцээ
1.	цемент	П-42,5	Хөтөл “ЦШ” ХК	2000 тн
2.	хайрга, дайрга	5-10,10-20 мм	“Сонголон хайрхан”ХХК карьер	4000 м ³
3.	элс	0-5 мм	“Сонголон хайрхан”ХХК карьер	3000 м ³
4.	Нэмэлт	Уян налархайжуулагч, усны орц багасгагч	“Талын торгон зам” ХХК	14 тн

Дүүргэгч материал: Дайрганы ширхэгийн хэлбэр нь үндсэн чулуулгийн төрөл, бүтэц болон бутлах төхөөрөмжийн төрөл, ажиллах зарчмаас хамаарна. MNS 0390:1998, MNS 0392:2014 стандартуудын шаардлага хангасан дайрга байх ба энэ тохиолдолд нимгэн үзүүрлэг хэсэг нь 15%-ийн бага буюу 2-5 %-ийн хооронд байдаг. Элсний ширхэгийн модуль нь >2.5 >3.0 байдаг бол 2.68 (том ширхэглэлтэй элс) тоос шавар шорооны хольц 0.4 %-иас ихгүй байдаг.

Элс: бетон зуурмагт хэрэглэгдэх элс нь 2.5 мм-с 0.14 мм хүртэл шигшүүрээр шигшигддэг бөгөөд MNS 0392 :2014 стандартын шаардлага хангасан элс юм.

Нэмэлт бодис: Бетоны физик- механик чанар (дундаж нягт, бат бөх, удаан эдэлгээт чанар, ус-хүйтэн-хортой үйлчлэл тэсвэрлэх чанар гэх мэт) зэрэг үзүүлэлтүүдийг тохируулах, цемент хэмнэх гэх мэт олон зорилгоор бетонд янз бүрийн нэмэлтийг цементийн жингийн тохирох хувийг нэмнэ. Бетон зурмагт хэрэглэгдэх нэмэлт бодисыг эрдэс гаралтай болон химийн гаралтай нунтаг нэмэлтүүд гэж хоёр ангилна.

- *Химийн нэмэлт:* Бетоны физик-механикийн болон технологийн шинж чанарыг шаардлагатай чиглэлд өөрчлөх үйлчилгээтэй. Усны орц багасгаж, барьцалдах хугацааг удаашруулах нэмэлтүүд лигносульфатын натри, кальци, аммонын давсууд хамаарна.
- *Эрдэс гаралтай нунтаг элементүүд:* эдгээр нэмэлтүүдийн үндсэн хэсэг нь шиллэг төлөвийн цахиурын исэл байна. Энэ исэл нь ердийн нөхцөлд портландцементийн бэхжилтийн үед түүнийг бүрдүүлэгч эрдсүүдийн гидролизоор үүссэн шохойн гидраттай урвалд орж өндөр бат бэхтэй төдийгүй үзүүлэлт сайтай шинэ нэгдэл үүсгэнэ.

MZ-01, MZ-02 бүтээгдэхүүн нь химийн орц найрлагын хувьд поликарбонилатын нийлмэл эфир давамгайлсан бөгөөд натри, кальци, давс бүхий полимерийн нэгдэл юм.

1.2.6 Бетон зуурмагийн нэмэлт бодисын шинж чанар, хор аюул

Уян налархайжуулагч болон хүйтний нэмэлт нь аюул ослын тодорхойлолтоор хор хөнөөлтэй гэж тогтоогдоогүй. Харшил өгөх эсвэл их хэмжээгээр тархсан тохиолдолд үрэвсүүлэх магадлалтай байна. Бүтээгдэхүүний эрүүл мэндийн аюулын ангиллаар XI цочроогч, эрсдэлийн хэв маяг Я43-арьсанд хүрсэн тохиолдолд мэдрэмтгий чанар үүсгэнэ.

Хүснэгт 1-2. Бүтээгдэхүүний онцлог

Үзүүлэлт	Тайлбар	Анхны тусламжийн арга хэмжээ
Эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөө		



Амьсгалахад		Хамрын салстлаг бүрхүүлд харшил өгөх магадлалтай	Амьсгалсан тохиолдолд цэвэр агаарт гарах
Нүдэнд тохиолдолд	орсон	Нүдэнд хүрсэн тохиолдолд бага зэргийн харшил өгнө	Нүдээ урсгал усаар 15 минутын турш зайлах, Линзээ авах, нүдээ нээлттэй байлгах
Арьсанд тохиолдолд	хүрсэн	Удаан хугацаагаар эсвэл олон удаа хүрсэн үед харшил үүсгэнэ	Бохирдсон гутал хувцсыг нэн даруй тайлах, их хэмжээний урсгал усаар сайтар савандаж угаах
Залгисан тохиолдолд		Бөөлжих, огиудас хүрэх зэрэг шинж тэмдэг илэрч болзошгүй	Амаа усаар зайлж дараа нь ахиухан ус уух
		Эмчид өгөх дагалдах бичиг	Эмчилгээг гадаад шинж тэмдгийн дагуу хийнэ

“MZ-01, MZ-02” нь уян налархай байдлыг хадгалах төрлийн суперпластификатор шингэн (химийн нэмэлт бодис) энэ ангилалын нэмэлт нь зуурмагийн уналт сайтай, ус зарцуулалтыг багасгадаг тул бетон зуурмагийн зууралтын үзүүлэлтийг дээшлүүлж бетон цутгалтын болон помпоор шахахад уян налархай гулгамтгай шинж чанартай болдог оос гадна бэхжилтийн явцыг нэмэгдүүлэх тал дээр мөн онцгой сайн үйлчлэл үзүүлдэг. Энэхүү нэмэлтийг энгийн бетон, автопомпоор шахдаг бетон, мөн өндөр маркын, хурдан бэхжидэг бетон зуурмагт өргөнөөр хэрэглэдэг. Ялангуяа өндөр маркын хүнд бетон, угсармал төмөр бетонд тохиромжтой.

Онцлог шинж:

- Бетоны урсамтгай чанарын хадгалах хугацааг сайжруулдаг.
- Удаан хугацаанд хол зайнд тээвэрлэх боломжийг бүрдүүлж өгдөг.
- Уян налархайжих чанарын алдагдлыг бууруулдаг.
- Материалийн алдагдлыг бууруулах ба эдийн засгийн хэмнэлт гаргах боломжтой.

Хэрэглээ:

- Шахалтын бат бэх өндөр, урт настай байх шаардлагатай гүүр, өндөр барилга байгууламж.
- Шингэн байгалийн хийн бааз, хурдны зам, метроны барилга, туннел г.м байгууламж.
- Үнс, зуухны шаарга, цахиур шороо их хэмжээгээр агуулсан бетон.
- Өөрөө тагтарших бетон зуурмаг.

Савлагаа:

1тн –ны хуванцар PVC савлагаатай. MNS ASTM C494/C494 MNS EN 934-1, EN934-2 /Бетонд хэрэглэх нэмэлтийн Техникийн шаардлага/ Бетоны химийн нэмэлтүүд нь стандартын шаардлага хангасан ус, цементийн зарцуулалт багасган бэхжилтийг түргэсгэх, уян налархайжуулах буюу бетон хольцын хөдөлгөөнт чанарыг сайжруулах, хольцийг өөрөө дагтарших чадвартай болгох, бат бэхийг нэмэгдүүлэх үндсэн үйлчилгээтэй. Усны зарцуулалтыг 15-20% -иар бууруулна.

Мөн нэмэлттэй бетон ба төмөр бетон бүтээц эдэлхүүнийг уураар бэхжүүлэн хэрэглэж болно. Хлор ионы агууламж, натри хлорийн агууламж нь бага тул гангийн (арматур) зэврэлтээс хамгаална.

1.2.7 Бетон зуурмагт нэмэлт бодис хийхийн давуу тал

Поликарбоксилат төрлийн нэмэлт нь усны хэрэглээг 30 % багасгаж, уян налархайжуулан, бат бэхийг нэмэгдүүлж, нягтаршил сайтай болгодог шинж чанар агуулснаараа бусад төрлийн нэмэлтүүдийг халж чадсан. Поликарбоксилат буюу ПИСИ (РС) нэмэлт бөгөөд бетонд нэмэлт хэрэглэснээр 1м³ бетонд хэрэглэгдэх усны зарцуулалтыг багасгаж, уян налархайжуулах чанарыг сайжруулж, бат бэхийн үзүүлэлтийг өндөрсгөж, бетонд агаарын агууламжийг үүсгэж бетоны хүйтэн тэсвэрлэлтийг дээшлүүлж, арматурыг зэврэлтээс хамгаалж, ан цав хагарлаас хамгаалан, ус тусгаарлах гэх мэт олон төрлийн үйлчилгээ үзүүлж бетоны механик чадварыг дээшлүүлдэг маш олон талын ашиг тустай. Мөн хүйтний үед бетон доторх ус хөлдөн эзлэхүүнээ тэлсний улмаас бетоны гадаргууд талст болон ан цав хагарал үүсдэг. Тиймээс агаар үүсгэгчтэй нэмэлтийг хэрэглэснээр бетон дотор нүх сүвний нимгэн хана үүсгэн бетоны хүйтэн тэсвэрлэлтийг дээшлүүлж мөн бетоной ажиллах боломжийг нэмэгдүүлж эдэлгээ, насжилтыг уртасгадаг.



1.2.8 Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Хүснэгт 1-3. Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

№	Тоног төхөөрөмж	тоо	марк	Хүчин чадал
1.	200 тн пресс	1ш	STYE-2000	220V
2.	Автомат шигшүүр	1ш	STSJ-3	220V
3.	Хатаагуур зуух	1ш		220V
4.	1000 нарийвчлалтай жин	1ш	HS420S	-
5.	30кг лабораторийн жин	1ш	JSB30-1	-
6.	Агаар агууламж үздэг багаж	1ш	-	-
7.	Цилиндр сав	3ш	-	2000мл, 500мл, 100мл
8.	Лабораторийн 50л багтаамжтай зуурдаг тогоо	1ш		220V
9.	100×100×100 хэв	30ш		
10.	52м-ын помп	1 ш		
11.	Миксер машин	7 ш		
12.	Бетон зуурах тогоо	1 ш		
13.	Туузан дамжуулагч	1 ш		

1.3 ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж: Тус үйлдвэр нь Дархан хотын төвийн шугамаар цахилгааны хэрэглээгээ хангадаг.

Усан хангамж: Тус компани нь Дархан-Ус суваг ХК-тай цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээтэй.



БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй: Төслийн талбай нь Хангай- Хэнтийн уулархаг их мужийн баруун хойд салбар уулсын хүрээнд Шарын голын районд харьяалагдана. Гадаргуугийн хамгийн нам цэг нь Шарын голын хөндийд 790 м, хамгийн өндөр цэг нь талбайн урд хэсэгт орших Их Дархан уул 1242.3 м хүрэх бөгөөд харьцангуй өндөржилт нь 50-600 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Нийт нутаг нь өвс ургамлаар бүрхэгдсэн, чулуулгийн гарш илэрц муу, харин уулын өмнөд хажуунууд чулуулгийн гарш илэрц сайтай, заримдаа бага хэмжээний нуранги, хад цохиотой байдаг.

Уур амьсгал: Төслийн талбай байрлах Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны уур амьсгалын мужлалын ерөнхий ангиллаар хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй мужид хамаарагдана. Уг бүс нутагт VII сарын дундаж агаарын температур нь +17- (+20)°C, хоногийн дундаж агаарын температур +10°C-ын заагийг хавар V сарын сүүлч, намар IX сарын дунд үед тус тус дайрч, энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 111-120 хоног, уулархаг хэсэгтээ 105-110 хоног байдаг. Энэ хугацаанд 1750-2250°C-ын нийлбэр дулаан хуримтлагддаг. Хаврын цочир хүйтрэл олон жилийн дунджаар V сарын 25- аас VI сарын эхээр шувтарч, намрын анхны цочир хүйтрэл VIII сарын сүүлч, IX сарын эхээр тохиолддог.

Усан орчин: Төслийн талбай нь олон жилийн цэвдгийн тархалтын бүслүүрийн хувьд олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжилсэн тархалттай бүслүүрт хамаарч байна. Мөн төслийн талбай нь Хараа голын сав газарт хамаарагдах бөгөөд ойр орчимд ил усны тогтолцоо болох үндны ус, гол горхи, булаг шанд байхгүй байна. Төсөл хэрэгжих талбайд голын сүлжээ сайн хөгжсөн ба үндсэндээ Ерөө голын /Орхон голын баруун цутгал/ болон Хараа голын сав газарт хамаарна.

Хөрсөн бүрхэвч: Сонголон Хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр орчмын бүс нутаг нь хээр бүхий экосистемтэй, д.т.д 693-709м үнэмлэхүй өндөртэй дэнж гүвээ болон голын хөндий бүхий газрыг дамнан байрлах бөгөөд хөрсөн бүрхэвч нь хүрэн хөрсний дэд хэв шинжид багтах элсэнцэр хүрэн төрлийн хөрс тархсан байна. Элсэнцэр хүрэн хөрс талбайн 95% орчимд зонхилон тархсан байна. Элсэнцэр хүрэн хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин бага буюу ялзмагийн агууламж нь 1-2%, дундаж зузаан үе давхаргатай, хөрс үүсгэгч хурдас нь чулуу багатай нарийн элсэрхэг ба тоосорхог хагшаастай, шороон зам зэрэг техникийн нөлөөтэй эвдрэл талхагдалд дунд зэрэг тэсвэртэй, эргэж нөхөн сэргэхдээ мөн дунд зэрэг байна.

Ургамлан нөмрөг: Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумын нутаг дэвсгэр нь Монгол орны ургамал-газарзүйн тойргоор Монгол Дагуурын ойт хээрийн тойрогт багтдаг. Төслийн талбай нь голын хөндий, нам дор газар бөгөөд дэрс-улалжит бүлгэмдэл зонхилж ургасан. Талбайд 9 овгийн 13 төрлийн 14 зүйл дээд ургамал бүртгэгдсэн.

Амьтны аймаг: Төслийн талбайн орчимд тохиолдох боломжит зүйлүүдээс ховордож болзошгүй хоёр амьтан /үнэг, хярс/ байна. Шувуудаас төслийн талбайд элбэг тохиолдох 5 багт хамаарах 16 зүйл байна. Эдгээр шувууд нь оршин амьдрах хэлбэрээр өндөглөн зусдаг болон суурин шувууд байна. Төслийн талбай орчимд хоёр нутагтан, мөлхөгчдийн цөөн хэдэн зүйл тархсан байна. Үүнд гүрвэлээс цоохор хонин гүрвэл *Phrenocephalus versicolor*, монгол гүрвэл *Eremias agrus*, могойноос бамбай хоншоорт *Gloydus halys*, Рашааны могой *Elaphe dione* зэрэг тохиолдох боломжтой юм. Ховор болон нэн ховор зүйлүүд хайгуул судалгаагаар тэмдэглэгдээгүй байна.

Дархан-Уул аймаг: Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд хэсэгт Хэнтийн нурууны салбар уулсын дунд Хараа голын зүүн хойд хөндийг хамарсан 327.5 мянган га газар нутагтай. Нийт газар нутгийн 70.7 хувь буюу 231.7 мянган га газрыг ХАА-н эдэлбэр газар эдэлдэг. Засаг захиргааны нэгжийн хувьд Дархан, Орхон, Хонгор, Шарын гол гэсэн 4 сум, 26 багтай.

Дархан сум: Монгол орны аж үйлдвэрийн томоохон төв Дархан хотын анхны суурийг тухайн үеийн Давхрын төмөр замын өртөө, барилгын түүхий эдийн ордуудыг түшиглэн 1961 оны X сарын 17-ны өдөр тавьсан юм. УИХ-н 1994 оны 32-р тогтоолоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Дархан хотыг Дархан-Уул аймаг болгон өөрчилсөн. Тус хот нь хуучнаар эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн орнууд болох Зөвлөлт



Сонголон Хайрхан ХХК-ийн Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дах
Бетон зуурмагийн үйлдвэрийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

Холбоот Улс, Болгар, Польш, Унгар, Чехословак, Герман зэрэг улсуудын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтайгаар байгуулагдсан. Мөн Дархан хотыг Найрамдлын хот хэмээн нэрлэсээр ирсэн. Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд хэсэгт Хэнтийн нурууны салбар уулсын дунд Хараа голын зүүн хойд хөндийг хамарсан 327.5 мянган га газар нутагтай. Нийт газар нутгийн 70.7% буюу 231.7 мянган га газрыг ХАА-н эдэлбэр газар эдэлдэг. Тус аймгийн газар нутгийн хэмжээ бага боловч алт, шохойн чулуу, нүүрс, барилгын материалын төрөл бүрийн түүхий эд зэрэг байгалийн баялгийн нөөц ихтэй.



БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Бетон зуурмагийн үйлдвэр төслийн нийт хугацаанд агаарын чанарт үзүүлэх гол нөлөөлөл нь хөрс хуулах, овоолго үүсгэх, хүдэр бутлах, машин механизмын хөдөлгөөнөөс тоос босох, дуу чимээ үүсэх, хорт хий ялгарах зэрэг үйл ажиллагаанууд хамаарч байна. Тухайлбал:

- Материал буулгаж ачих үед тоос, тоосонцор үүсэх
- Бүтээгдэхүүн тээвэрлэх шороон замаас тоос, тоосонцор үүсэх
- Тээврийн хэрэгслийн зарцуулах түлшний шаталтаас агаар бохирдуулагч бодис ялгарах

3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Үйлдвэрийн сул талбайг зүлэгжүүлээгүй, хатуу хучилттай болгоогүй тохиолдолд хөрс талхлагдах
- Хог хаягдлыг стандарт шаарлага хангасан саванд ангилан цуглуулаагүй улмаас хог хаягдал салхиар зөөвөрлөгдөх тархах
- Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарах, химийн бодис асгарсны улмаас хөрсөнд нэвчин хөрсийг бохирдуулах

3.3 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Тээвэрлэх явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр зам дагуух ургамлан нөмрөг талхлагдах
- Химийн бодисын буруу хадгалалт тээвэрлэлт зэргээс үүдэн сав баглаа боодол задарч химийн бодис гадагш алдагдах, асгарч гоожих, шатах тослох материал асгарах зэргийн улмаас ургамлан нөмрөг бохирдож болзошгүй

3.4 ХОГ ХАЯГДЛЫН УЛМААС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Ахуйн хог хаягдал: Үйлдвэрт нийт 4 хүн ажиллах бөгөөд нэг хүн хоногт 0.5 кг хог хаягдал гаргана гэж тооцоолоход өдөрт 2 кг, жилд 0.42 тонн хатуу хог хаягдал үүсэхээр байна.
- Шингэн хог хаягдал: Төслийн ахуйн хэрэглээнд хоногт 600 л үс хэрэглэх бөгөөд үүний 70 хувийг ахуйн шингэн хаягдал болно гэж тооцвол хоногт дунджаар 420 л буюу 0.42 м³ шингэн хаягдал гарахаар байна.
- Аюултай хог хаягдал: Хаягдал тос ба шингэн түлшний хаягдал, хаягдал дугуй, батарей, машин механизмыг задлах болон засварлах үйл ажиллагаанаас гарах хаягдлууд үүсэж болзошгүй байна.



БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, мөн сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болох магадлалтай сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой эрх зүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардлагатай хөрөнгө зардлыг тодорхой тусгаж, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд гарах өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах арга хэлбэр, шаардлагатай хөрөнгө, зардал, хугацааг нарийвчлан тусгахаар хуульчилсан байна. Ийм үндэслэлээр БОМТ болон ОХШХ-ийг боловсруулсан болно.

4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2026 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба 2026 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд **5,741,000** төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 4-1: 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,315,000
2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	730,000
3.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,450,000
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	360,000
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	886,000
Нийт зардал		5,741,000

4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд нийт 6 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд байгаль орчны газраас даалгасан нэмэлт үүрэг, даалгавруудыг хийхээр төлөвлөв. Компанийн хэрэгжүүлсэн ажлуудыг 2025 он хүртэл дараах байдлаар гүйцэтгэн, тогтмол хянаж, тайлагналын дагуу үргэлжлүүлж байна:

- Үйлдвэрийн хашаан дах нийт 0.8 га талбайд сар бүр тогтмол нягтаршуулалт хийж, 5–9 сард тоосжилт дарах усалгааг гүйцэтгэж, орчны агаарт үзүүлэх нөлөөллийг бууруулсан.
- Үйлдвэрт хэрэглэгддэг зуурмагийн миксерийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуваарьт үзлэг, жил бүрийн улсын тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд хамруулан хэвийн ажиллагааг хангаж ажилласан.
- Үйлдвэрээс оффис хүртэл 0.01 км авто болон явган хүний замыг сайжруулж, хатуу хучилттай болгосон.



- Хөрсөн бүрхэвч талхлагдахаас хамгаалах зорилгоор үйлдвэрийн тээврийн зогсоолд хурд хязгаарлалтын болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.
- Болзошгүй шатах тос, бетоны нэмэлт бодисын алдагдалд тохиолдолд саармагжуулах, гал унтраах хэрэгслийг үйлдвэрийн хашаанд болон харуулын байшингийн хажууд байршуулсан.
- Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны БОМТ-ний хүрээнд үйлдвэрийн хашаанд 10 ш модыг тарьж, арчилгаа тордолгоог хийсэн бол 2024 онд үйлдвэрийн баруун талд 20 ш модыг нэмж тарьсан. Мөн 2025 онд үйлдвэрийн талбай дотор нэмж 40 ш модыг тарьсан ба эдгээр моддын болон цэцэрлэгжүүлэлтийн талбайн арчилгаа тордолгоог хийв.
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин ашиглагдахгүй энгийн хогийг Дархан хотын Төхижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлсэн.
- Усны хэт хэрэглээнээс сэргийлж зөвлөмж байршуулж, ажилчдад сургалт хийсэн.
- Усны тоолуурын дагуу Дархан ус суваг ХК-д усны төлбөрийг төлж, ус хэмнэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг зэрэг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэн 2026 оны БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Хүснэгт 4.2-д тусгасан.



Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанар									
1.	Бутлуурын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт	Бутлуурын ойр орчимд зохиомол мананжуулагч эсвэл, бороожуулагч суурилуулан тоос дарах	Бутлуур	1	Цогц	ҮАЗ*		Байнгын	
2.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх	Үйлдвэрийн 0.8 га талбайн сайжруулсан замын тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх	үйлдвэрийн дотоод зам талбай	0.8	Га	ҮАЗ*		5-9 сард 1 удаа	-2022-2026 оны БОМТ-ний 6.3.1-т тусгаснаар -Эрүүл ахуйн тухай хууль -MNS:5011:2020. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага
3.	Тээврийн хэрэгслүүдийн түлшний шаталт агаар орчныг бохирдуулж болзошгүй	Үйлдвэрт хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдээс (миксер) ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, хуваарьт үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах	миксер	5	Ш	25,000	125,000	Жилд 1 удаа	
Хөрсөн бүрхэвч (газрын гадарга)									
4.	Хөрсний эвдрэл	Үйлдвэрээс оффис хүртэл хатуу хучилттай болгосон замын арчилгааг хийх	үйлдвэрийн дотоод зам талбай	0.01	Км	-	-	Улиралд 1 удаа	-2022-2026 оны БОМТ-ний 6.3.1-т тусгаснаар -Эрүүл ахуйн тухай хууль, 4.4.3
5.	Хөрсний бохирдол үүсэх	Болзошгүй байдлаар шатах тослох материал, бетоны нэмэлт бодис алдагдсан тохиолдолд хэрэглэх саармагжуулах иж	Үйлдвэр, галын булан	2	Ш	150,000	300,000	Жилд 1 удаа	



Сонголон Хайрхан ХХК-ийн Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дах
Бетон зуурмагийн үйлдвэрийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
		бүрдлийн хэрэгслийг нэмж байрлуулах							
6.	Хөгс хаягдлаар хог бохирдох	Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	үйлдвэрийн талбай	12	удаа	50,000	600,000	Сард 1 удаа	
7.			орчны 50 м	4	удаа	50,000	200,000	Улиралд 1 удаа	
8.	Хөгс талхлагдах	Тээврийн хэрэгслийн зогсоолд хурдны болон тэмдэг тэмдэглэгээг арчлах, бүрэн бүтэн байдлыг хянах	авто машины зогсоол	12	удаа	-		Сард 1 удаа	
9.	Байгалийн гаралтай цацраг идэвхт элемент (Ra-226, Th-232, K-40) бетон зуурмагт агуулагдах, барилга ашиглалтын үед хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл	Итгэмжлэгдсэн лабораториор бетон зуурмаг болон түүхий эдээс дээж авч гамма-спектрометрийн шинжилгээ хийх; стандартын хязгаараас хэтэрсэн тохиолдолд тухайн түүхий эдийг ашиглахгүй байх	Барилгын зориулалтаар ашиглах бүх бетон зуурмаг	2	Удаа	45,000	90,000	Жилд 1 удаа	Холбогдох шаардлага, стандартын дагуу



Сонголон Хайрхан ХХК-ийн Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дах
Бетон зуурмагийн үйлдвэрийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	2	3	4	5	6	7	8	9		
Усан орчин										
10.	Ил задгай хог хаяснаар усан орчныг бохирдуулах	Стандарт шаардлага хангасан хогийн саванд хог хаягдлын ангилан ялгах	үйлдвэрийн бие засах өрөө болон гал тогоо	12	удаа	ҮАЗ*		Сард 1 удаа	Дархан-Ус суваг ХК-тай байгуулсан Цэвэр усаар хангах, бохир усыг татуулах гэрээ	
Ургамлан нөмрөг										
11.	Ногоон байгууламжийн ургалт муудах	Үйлдвэрийн хашаанд тарьсан моддыг усалж, арчилгаа тордолгоог хийх	Мод тарьсан талбай	30	ш	ҮАЗ*		4.20-5.1 (1), 5.1-6.1 (4), 6.15-8.15 (9), 8.15-9.15 (2)	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4	
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал							1,315,000 ₮			

Тайлбар: ҮАЗ* - Үйл ажиллагааны зардалд тусгах



4.4 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны БОМТ-ний хүрээнд үйлдвэрийн хашаанд 10 ш модыг тарьж, арчилгаа тордолгоог хийсэн бол 2024 онд үйлдвэрийн баруун талд 20 ш модыг нэмж тарьсан. Мөн 2025 онд үйлдвэрийн талбай дотор нэмж 40 ш модыг тарьсан ба эдгээр моддын болон цэцэрлэгжүүлэлтийн талбайн арчилгаа тордолгоог хийв. 2026 онд мөн үргэлжлүүлэн 100 моддыг тарьж, хашаалах ба усалгааг тогтмол хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 4-3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Суулгац авах	үйлдвэр	ш	100	5,000	500,000	2026 оны хавар эсвэл намрын улиралд тариалах	-Мод тарих гарын авлага
	Мод услах (усны машин)		ш	1	150,000			
	Ажилчдын цалин		хүн	1	80,000	80,000		
Нийт зардал				730,000 ₮				

4.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-т “ Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологийн мэргэжлийн байгууллагаар уг газарт урьдчилан хайгуул, малтлага, судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулна” гэж тусгасан байдаг бөгөөд Бетон зуурмагийн үйлдвэр нь 2026 онд шинээр барилга байгууламж нэмж барихгүй учраас түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй. Харин Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасныг баримтлан ажиллах нь зүйтэй.

4.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд нийт 6 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Сонголон Хайрхан ХХК нь осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2025 он хүртэлх хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Тус үйлдвэрт 2012 онд Эс Эй Эн Ди ХХК-иар 6/0.4 кВ-ын ЦДАШ иж бүрнээр суурилуулсан бөгөөд тэдгээрийн хэвийн ажиллагааг хангаж сар бүр шалгаж ажиллаж байна.
- Бетон зуурмагийн үйлдвэр нь нийт 20 ажилтантай бөгөөд ХАБЭА сургалтыг шинээр ажилтан авах бүрт, мөн жил бүр ХАБЭА давтан сургалтыг зохион байгуулдаг. Үүний дагуу 2025 он хүртэл компанийн нийт ажилчдыг ХАБЭА сургалтад хамруулсан байна.
- Сонголон Хайрхан ХХК нь 2022.04.10-ний өдрийн № 12 тоот компанийн дотоод тушаалаар “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс”-ыг байгуулж, асгаралтаас сэргийлэх дотоод журмыг боловсруулан, түүнийг дагаж мөрдөн ажиллаж байна.

Сонголон Хайрхан ХХК нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллахаар 2026 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд **1,450,000 ₮** зарцуулахаар байна.



Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4		6	7	8	9
1.		Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах	Ажилчид	-	-	-	Өдөр бүр	Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс"-ыг байгуулсан асгаралтаас сэргийлэх дотоод журам
2.	Үйлдвэрт ажиллаж буй ажилчид бэртэж, гэмтэх	Ажилчдыг үргэлжлүүлэн ХАБЭА сургалтад хамруулах		4	350,000	1,400,000	Улиралд 1 удаа	
3.		Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрт ажиллах аюулгүйн санамжийн самбарын бүрэн бүтэн байдлыг шалгах	Үйлдвэр, оффис		-		Улиралд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
4.	Гал түймэр	Үйлдвэрийн галын хорыг цэнэглэж, ажиллагааг хангах	Галын булан	-	50,000	50,000	Жилд 1 удаа	
Нийт зардал						1,450,000 ₮		

4.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд нийт 7 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Сонголон Хайрхан ХХК нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2025 он хүртэлх хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Аюултай хог хаягдлыг бүртгэлийн дэвтэрт цаг тухайд нь тэмдэглэн, гэрээт компанийн тусламжтайгаар тээвэрлэн устгуулсан. Үүнд тээврийн хэрэгслийн дугуй, тоормосны шингэн, түлшний тос, түлш хийсэн хуванцар сав зэрэг хог хаягдал багтсан.
- Хог хаягдлын цэгийн ойр орчимд сар бүр хоёр удаа цэвэрлэгээ, ариутгал хийж, орчны бохирдлыг бууруулсан.
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ахуйн, дахин ашиглах боломжтой, аюултай гэсэн ангиллаар ялгасан. Дахин ашиглагдахгүй энгийн хогийг Дархан хотын Тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлэж, Дархан сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлсөн.



Сонголон Хайрхан ХХК-ийн Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дах
Бетон зуурмагийн үйлдвэрийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

- Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад нийлүүлэн устгуулж, орчны аюулгүй байдлыг хангаж ажилласан.



Сонголон Хайрхан ХХК-ийн Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дах
Бетон зуурмагийн үйлдвэрийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

Хүснэгт 4-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн	Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад тээвэрлүүлэх, актаар хүлээлгэж өгөх	үйлдвэр	12	удаа	20,000	240,000	Сард 1 удаа	-Хог хаягдлын тухай хууль
2.		Хог хаягдлын бүртгэл хөтлөх	үйлдвэр					Өдөр бүр	
3.		Хогийн сав болон цэгийг цэвэрлэх	Хогийн цэг	12	удаа	10,000	120,000	Сард 1 удаа	
4.	Аюултай	Тээврийн хэрэгслийн ашиглалтаас гарсан дугуй, тоормосны шингэн, түлшний тос, түлш хийсэн хуванцар сав, зэрэг аюултай хог хаягдалд хамаарах үүссэн аюултай хог хаягдалд бар код нааж, эрх бүхий байгууллагад нийлүүлж, устгуулах	Тээврийн хэрэгслийн хаягдал	-	-	Гэрээт байгууллагын үнийн саналын дагуу хүлээлгэж өгөх		Улиралд 1 удаа	-Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, Тээвэрлэх, дахин боловсруулах, устгах Болон бүртгэх, тайлагнах журам
Нийт зардал							360,000 ₮		



4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний чухал хэсэг юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1.5-т зааснаар Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана.

Сонголон Хайрхан ХХК нь 2025 оны БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Агаарт орчны тоосжилт, агаар бохирдуулагч хийг тодорхойлуулсан
- 3 цэгээс дээж авч хөрсний ерөнхий хими болон хүнд металлыг тодорхойлуулсан

Бетон зуурмагийн үйлдвэрийн 2026 оны үйл ажиллагааны явцад Хүснэгт 4-6-д тусгасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг доорх хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ. Үүнд:

Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр буюу Сонголон Хайрхан ХХК нь үйлдвэрийн үйл ажиллагаанаас бий болж буй үр дагавруудыг хянах, илрүүлэх зорилгоор үйлдвэрийн талбайд агаар, хөрс, усны шинжилгээг жилд 2 удаа хийх

Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1 удаа хийлгэх, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулах, дүгнэх

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Сонголон Хайрхан ХХК бүрэн хариуцна.



Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	
Агаарын чанар							
1.	<ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) Агаарын температур, чийг 	Үйлдвэр, оффис	2	Жилд 2 удаа	300,000	600,000	MNS.4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаарын чанар (хөндлөнгийн хяналт)							
2.	<ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) Агаар бохирдуулагч хий (SO₂, NO₂) Дуу чимээ 	Үйлдвэр, оффис, хяналтын цэг	3	Жилд 1 удаа		ҮАЗ*	MNS.3384:1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч							
3.	<ul style="list-style-type: none"> Хөрсний хими болон физикийн ерөнхий шинжилгээ 	үйлдвэрийн хашаан дотор, машины зогсоол, хяналтын цэг	3	Жилд 2 удаа	40,000	240,000	MNS.2305:1995. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх
Хөрсөн бүрхэвч (хөндлөнгийн хяналт)							
4.	<ul style="list-style-type: none"> Хөрсний хими болон физик Хүнд металл 	үйлдвэрийн хашаан дотор, машины зогсоол, хяналтын цэг		Жилд 1 удаа		ҮАЗ*	MNS.5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усан орчин (хөндлөнгийн хяналт)							
5.	<ul style="list-style-type: none"> Үйлдвэрийн ундны усыг шинжлүүлэх 	Үйлдвэр		Жилд 1 удаа	46,000	46,000	MNS.6230:2010. Бохир ус зайлуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага
Ургамлан нөмрөг (хөндлөнгийн хяналт)							
6.	<ul style="list-style-type: none"> Ургамлын зүйлийн бүрдэл Ургамлан нөмрөгийн бүрхэц 	Үйлдвэр	-	Жилд 1 удаа		ҮАЗ*	Батлагдсан арга зүйн дагуу
Нийт зардал					886,000 ₮		

Тайлбар: ҮАЗ*- Үйл ажиллагааны зардалд тусгах



4.9 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд нийт 7 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2026 оны БОМТ-ний удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Ажилчдад ХАБЭА, үйлдвэрийн осол, химийн бодистой харьцах зэрэг сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулдаг.
- Сонголон Хайрхан ХХК нь Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран үйлдвэрийн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг бөгөөд хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангадаг.
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн 10¹ дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллага болох Энвайроментал Комплайнц ХХК-р хийлгүүлсэн.

2026 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг Хүснэгт 4-7-д тусгав.

Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2026 он			
			IV	VIII	XII	
	1	2	3	4	5	6
1.	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулах	1,000,000		+		ХАБЭА ажилтан
2.	Ажилчдыг үргэлжлүүлж эрүүл мэндийн үзлэгт хамруулах	ҮАЗ*	+			Удирдлага
3.	Газрын гэрээг дүгнүүлж, акт авах	ҮАЗ*			+	Хариуцсан мэргэжилтэн
4.	Жил бүр БОМТ-г батлуулж, биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн БОАЖГ-т хүргүүлэх	-			+	Хариуцсан мэргэжилтэн
Нийт зардал			1,000,000 ₮			

Тайлбар: ҮАЗ* - Үйл ажиллагааны зардалд тусгах

Сонголон Хайрхан ХХК нь 2021.06.30 өдөр Энвайроментал Комплайнц ХХК-иар аудитыг хийлгэсэн. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дэх заалт болон Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасны дагуу 2 жил тутамд байгаль орчны аудитыг хийлгэх шаардлагатай учир 2025.10.30 өдөр Энвайроментал Комплайнц ХХК-иар аудитыг дахин хийлгэсэн.

4.10 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. БОМТ-г боловсруулж, БОУАӨЯ-нд батлуулахаар хүргүүлж, батлагдсаны дараа тухайн жилийн БОМТ-г ханган биелүүлж, түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор Дархан-Уул аймгийн БОГ-т хүргүүлнэ.

Хүснэгт 4-8. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах	Тайлагнах зардал, сая төг	Хариуцсан зохион байгуулах албан	Зохион байгуулах газар
---	---------------------------------	------------------	--------------------	------------------	---------------------------	----------------------------------	------------------------



оролцогч талууд		хугацааны тов			тушаалтан/ажил тан		
1	2	3	4	5	6	7	
1.	Дархан-Уул аймгийн байгаль орчны газар	Хэвлэмэл	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг тусгасан тайлан байна. Ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	11 дүгээр сарын 01-нээс өмнө	ҮАЗ*	Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн	Дархан-Уул аймаг
2.	БОУАӨЯ	Хэвлэмэл болон (www.eic.mn)	Тухайн жил хийх ажлын төлөвлөгөө	12 дугаар сарын 30-наас өмнө			Улаанбаатар хот

Сонголон Хайрхан ХХК нь жил бүр БОМТ боловсруулан БОУАӨЯ-аар батлуулж, БОМТ-нд тусгагдсан ажлуудыг ханган биелүүлж, БОМТ-ний биелэлтийн тайланг жил бүр Дархан-Уул аймгийн БОГ-т хүргүүлэх үүрэгтэй.



ДҮГНЭЛТ

Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2026 оны БОМТ-г боловсруулан дараах дүгнэлтийг хийж байна.

Бетон зуурмагийн үйлдвэрийн 2026 оны БОМТ-ний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 1.315 сая, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд 0.73 сая, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 1.45 сая, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 0.36 сая, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 0.86 сая, удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 1 сая төгрөг тус тус төлөвлөв.

Сонголон Хайрхан ХХК нь 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 5,741,000 төгрөг зарцуулан 30 ажил хийж гүйцэтгэхээр байна.



ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Хавсралтын нэр	Хуудас
1.	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	2
2.	Химийн бодис нийлүүлэх гэрээ	5
3.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас	5

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000188827

2008.12.17 / Бүртгэсэн он, сар, өдөр /

9011179051 / Хуулийн хэргийн дугаар /

5276764 / Регистрийн дугаар /

Сонголонхайрхан / Хуулийн этгээдийн нэр, харуулгавын хэлбэр /

Хязгаарлагдмал хариуцлагатай компани / Хуулийн этгээдийн нэр, харуулгавын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр / шийдвэрийн нэр /	01 / дугаар /	2008.12.17 / он, сар, өдөр /
-------------------------------	------------------	---------------------------------

0111 / код /	Газар тариалан эрхлэх / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /
0141	Фермерийн аж ахуй эрхлэх
4610	Гадаад худалдаа
0210	Гаарын хэвлийн нөхөн сэргээлт
7490	Хатуу хучилттай зам барих

/ код /

12.01.12~15.01.12 / хугацаа /	2 / гишүүдийн тоо /	2,452,970.0 / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /
----------------------------------	------------------------	--

Улаанбаатар, Сонголонхайрхан, 12-р хороо, 182, Утас1: 98009669, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 8 сар 28 өдөр

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын
бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгуулгавын нэр /



БАТЛАВ. БАТЛАВ.

ДАРХАН ХОТЫН ХОГ ТЭЭВЭР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
О. ЛОТГОНБЯАР

.....-н ЗАХИРАЛ/ДАРГА/
Дархан-Уул аймаг

No 33

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ТҮРЖ, БУЛЖ УСТГАХ ГЭРЭЭ

Гүйцэтгэгч талаас "ДАРХАН ХОТЫН ХОГ ТЭЭВЭР ОНӨААТҮГ"-г төлөөлж
ахлах байцаагч..... Т. Баермаа нөгөө
талаас..... газрын Ерэнхий мекенээр албан
тушаалтай Тэмболонговтой..... Шашид захиалагч тал гэх/ нар
нь "Монгол Улсын Хог Хаягдлын тухай хууль", Зөрчлийн тухай хууль" эдгээртэй
нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг үндэслэн харилцан тохиролцож энэхүү
гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь ААНБ-аас гарч байгаа ахуйн болон
энгийн хог хаягдлыг гэрээнд заасны дагуу ачиж тээвэрлэх, түрж булж устгах, захиалагч
тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөр төлөх, хог хаягдлыг ачиж тээвэрлэж Бараат
хогийн цэгийн талбайд буулгах харилцаа болон байгууллага хоорондын ажлын уялдааг
сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Нэг. Нийтлэг заалт

1.1 Захиалагч нь өөрийн байгууллагын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг өөрийн
тээврийн хэрэгслээр ачиж тээвэрлэн Дархан-Уул аймгийн Дархан сум 6-р баг Бараат
хогийн цэгийн талбайн тогтоосон цэгт буулгах, гүйцэтгэгч тал уг хог хаягдлыг түрж
булж устгах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

1.2 Гүйцэтгэгч тал хог хаягдлыг холбогдох хууль, тогтоомж, дээд газрьж шийдвэр,
журамд заасан хэм хэмжээний дагуу булж устгах ажлыг гүйцэтгэнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Энэхүү гэрээ нь 2025 оны 01 сарын ны өдрөөс 2025 оны 12 сарын 31-ний
өдрийг дуустал хугацаанд хучин төгөлдөр мөрдөгдөнө.

2.2 Гэрээний хугацаа дуусахад талууд харилцан тохиролцож сунгаж болно.

Гурав. Гэрээний унэ, төлбөр тооцоо

3.1 Гэрээний дагуу 1м3 хог хаягдлыг булж устгах, үйлчилгээний тарифыг -10,000
/арван мянга/-н төгрөгөөр тооцно. Төлбөрийг тухайн сарын 25-30-ны дотор тооцоо



Сонголон Хайрхан ХХК-ийн Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дах
Бетон зуурмагийн үйлдвэрийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

Бүх бэлтгэл, картга холбооно
ХААН БЭЛЭГЧИЛ: 0001-0001-0001



Орлогын мэдүүлэг

Дархан хотын хог тээвэр ОНӨААТҮГ

Хураамж төлсөн: 20... он ... сар

Бүгд дүн: 40,000 он сар өлөр

Барямтын: 30400

Хэнээс: ...

Хороолол: ...

Бичгээр: ...

Байцаагч: ...

Тушаагч: ...